

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
ХОЁРДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2020.01.31-2020.02.28/

2020 оны 02 дугаар сарын 28

Даланзадгад хот

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Виз, зөвшөөрлийн үйл ажиллагааны чиглэлээр:

Виз сунгалтын талаар:

Тайлант хугацаанд “Монгол Улсын Виз олгох журам”-ын 6.2-т заасны дагуу БНХАУ-ын 44 иргэний визийн сунгалт хийж ажилласан болно.

1.2 Тайлант хугацаанд Гашуунсухайт боомтын гарах чиглэлд зорчсон БНХАУ-ын нийт 15 иргэний баримт бичиг болон хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

Гашуунсухайт боомт

- Гарах чиглэл-15

1.3 Түр ирэгчийн бүртгэл, хасалт:

Тайлант хугацаанд 44 гадаадын иргэнд түр ирэгчийн бүртгэл, 44 иргэний хасалт хийж, мөн БНХАУ-ын 166 иргэнд оршин суух зөвшөөрлийн хасалт хийж ажилласан байна.

1.4 ХОНЗҮ-ээр зорчигч гадаад иргэдийн хяналтын талаар:

Тайлант хугацаанд хил орчмын нутагт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын 1 иргэнд хасалт хийж ажилласан.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Байгууллагын даргын 2020 оны 01 дүгээр албан даалгаврын биелэлтийг гарган долоо хоногийн даваа гариг бүр холбогдох нэгжид хүргүүлэн ажиллаж байна.

Тус газрын нийт 20 албан хаагчаас амьжиргааны түвшин тогтоох судалгааг гаргуулан нэгтгэн гаргасан. Мөн төрийн албан хаагчийн анкетийг цахим хэлбэрээр бөглүүлэн энэ оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэн ажилласан.

Хүний нөөцийн програмд 21 албан хаагчийн цалин, хоолны хөнгөлөлт, төрийн захиргааны 8 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэв, төрийн үйлчилгээний 1 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл зэрэг мэдээллийг тухай бүр нь шивж ажилласан.

Сар шинийн баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн хуваарийг батлан ажиллуулж төвийн хариуцлагатай жижүүрт тухай бүр нь мэдээг өгч ажилласан бөгөөд гарсан зөрчилгүй ажилласан болно.

2.1.Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/-1
- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо-1
- Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
- Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-1/
- Төв газарт явуулсан бичиг /илтгэх хуудас-7/
- Явуулсан бичиг /албан тоот-8/
- Бусад байгууллагаас ирсэн бичиг-5
- Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

2.2.Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Энэ оны 02 дугаар сард 43,276,400 төгрөгийн санхүүжилт авч нийт 20 албан хаагчийн цалинд 19,488,740 төгрөгийг олгож, нийгмийн даатгалын шимтгэлд 2,528,494 төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардалд 1,551,200 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 2,169,825 төгрөг, томилолтын зардалд 828,000 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 400,000 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан гүйлгээ хийж ажилласан байна.

Тус газрын 2020 оны 01 дүгээр сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг дараа сарын 02-ны дотор холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.

Тус газрын 2019 оны санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж Өмнөговь аймгийн Төрийн аудитад хүргүүлэн энэ оны 17-19-ний өдрүүдэд аудит хийлгэж ажилласан бөгөөд “Зөрчилгүй” санал дүгнэлт авч ажиллалаа.

2019 оны санхүүгийн аудитлагдсан тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 13/18 дугаар албан бичгээр Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлэн ажилласан болно.

2.3.Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд албан хаагчдаас сүлжээ тасалдсан, компьютерийн хэвийн бус ажиллагаатай холбоотой нийт 4 дуудлага ирүүлснийг тухай бүр засч сайжруулан ажилласан.

Гурав. Бусад

3.1 БНХАУ-д бүртгэгдсэн шинэ коронавирусын дэгдэлт ихэссэнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Өмнөговь аймгийн онцгой комисс болон байгууллагын даргын гаргасан шийдвэрүүдийг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Тухайлбал, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор халуун чацаргана, витамин, гар ариутгах бодисоор ханган, албаны өрөөнүүдийн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтлийг сайжруулан ажиллаж байна. Мөн байгууллагын даргын гаргасан албан даалгаврын биелэлт, уг

вирусээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР